

VIII БОГДЫН ӨНДӨР НЭР ХҮНД, СУУ АЛДАР - МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИН ДАХЬ ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН ЁС, ТОГТОЛЦООНЫ БАТАЛГАА БОЛЖ БАЙСАН НЬ

О. Батсайхан (Sc.D)

Олон улсын харилцааны хүрээлэн

ШУА

Түлхүүр үгс: Богд Жавзандамба, Богдын ёс, тогтолцоо,

Товч утга: XX зууны эхэн болоход Богд Жавзандамба хутагтын их шавийн шууд захиргаанд арван хэдэн мянган өрх, 100 мянга гаруй хүн ам, түүний дотор 20 гаруй мянган лам, 100 илүү хүрээ, хийд, тэдний жас харьяалагдаж байжээ. Харин Богдын шууд бус нөлөөнд 100 мянга гаруй лам, 1000 шахам сүм, хийд харьяалж байсан гээд үзвэл Богд гэгээний тухай ойлгоход арай дөхөм болбу. Богд гэгээний шавь нар бол олон хошуунаас өргөгдсөн хүмүүс байсан билээ. Богдын шавь нарын тоо ийм их олон тоотой болсон ч тэд тусгайлан эзэмшил нутаггүй байсан нь Богд Жавзандамба хутагтын монголчуудын дунд эзэлж байсан байр суурь, нэр хүндээс хамаарсан хэрэг юм. Анхдугаар Богд Жавзандамба хутагт Түшээт ханы гэр бүлээс гарсан тул тус аймгийн нутгийн дотор хамжлага шавь нартайгаа чөлөөтэй нүүдэллэн нутаглах эрхтэй байжээ.¹ Үүнийг Жавзандамба хутагтын элч Халхын гурван хошуунд улаа унах эрх бүхий байсан зэргээс тодорхой харж болно. “Улмаар Богд Жавзандамба хутагт Халх дахины тахьсан их лам, Монголын шарын шашины тэргүүн болсоноор Халхын хэмжээгээр түүний адил бүгдийг товчлон, эрх нөлөөгөө дэлгэрүүлэх хүн байхгүй болжээ”² хэмээн түүний нэр хүн, нөлөөллийн талаар эрдэмтэн Ш.Нацагдорж гуай нэгэнтээ тэмдэглэсэн буй.

Мөн түүнчлэн Манжийн хаан Жавзандамба хутагтыг Халхын шашины тэргүүн мөн гэж албан ёсоор баталж, түүний шавь нарыг Халхын ямар ч хошуунд нутаглаж болохыг зөвшөөрсөн нь Богд Жавзандамба хутагт, түүний ёс, тогтолцоо Халх даяар үйл ажиллагаа явуулах, нэр хүнд нөлөөгөө тэлэх боломжийг илүү олгосон хэмээн үзэж болно.

Анх 1650 онд Богд Жавзандамба хутагтад бараа бологч лам нар сангийн үйл ажиллагаа эрхлэх болж, шанзодба³ байгуулагджээ. 1651 онд Богдын хүрээнд Андун нар,

¹ Ш.Нацагдорж Сум, хамжлага, шавь ард 1972: 46

² Ш.Нацагдорж Сум, хамжлага, шавь ард 1972: 47

³ Шанзудба – монголоор мутрын сан баригч хэмээх утгатай үг. Монголын шашины тэргүүн Богд Жибзундамба хутагтын шавийн хэрэг, засаг захиргаа, санхүү, жас, аж ахуйгаас эхлээд тэдний явах суухыг хүртэл хамааран захирч байсан албан тушаал. Шанзудба нь Манж Чингийн үед Жибзундамба хутагтын Хүрээний хэргийг шийтгэх, шавь нарыг бүгд захирагч Эрдэнэ шанзудбын тамга хэмээх бичигтэй тамгатай байсан нь Жибзундамба хутагтын харьяат бүх шавь нар, тэдний хооронд гарсан зарга заальхай, хүн амь, хулгай худлын хэргийг шүүн таслах, Хутагтын мал сүрэг, сангийн хэргийг эрхлэх, Хүрээтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх эрх мэдэл бүхий тушаалтан байжээ. Эрдэнэ шанзудба нь Манж Чингийн үед Хамба номун ханы хамт Түвдээс тодорсон Жибзундамба хутагтын дүрүүдийг Монголд залж авчрах, хутагтын ширээнд өргөмжлөх ажлын Чингийн төрийн хяналт дор халхын дөрвөн аймгийн чуулган дарга нарын хамт зохион байгуулж байжээ. Шанзудба нь Хүрээний хамба номун ханы хамт Хүрээний сүм хийдүүдийн тэргүүлэх тушаалтнуудыг томилох, тэдний хэрэглэх ямба ёсыг тогтоох эрхтэй байжээ. Энэ нь түүний эрхэлсэн ажил, тухайлбал шавь нарт холбогдох хулгай худал, хүн амины зэрэг хэргийг шүүн шийдвэрлэх зэрэгт оролцдогтой холбоотой байжээ. 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан Монгол улсын эзэн хаан Богд Жавзандамбын зарлигаар Эрдэнэ шанзудбын яамны суурин дээр Шашины төрд туслах

Жас, Сангай, Зоогой, Хүүхэн ноёны, Дархан эмч, Өрлүүдийн гэсэн долоон аймаг байгуулагдав. Жасын аймаг нь Хүрээ, хийдийн хурал, номын зардлыг бэлтгэх ажлыг, Сангай аймаг нь Богдын сангийн аж ахуйг, Зоогой аймаг нь зоог шүүс бэлтгэх хэргийг тус тусдаа эрхлэн, үйл ажиллагааны зааг ялгаа тогтоосон байна. XX зууны эх болоход Богдын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг аймгийн тоо 30 хүрч, хамгийн сүүлд Эх дагинын аймаг байгуулагдсан гэдэг билээ. Эдгээр аймгууд Богд гэгээнтэний бүхий л үйл ажиллагааг тогтвортой, найдвартай хангах үүргийг хүлээж, түүнийгээ чанартай гүйцэтгэхийн төлөө улс орны өнцөг булан бүрээс төрөл бүрийн чадалтай хүмүүсийг урин залж ажиллуулдаг байв.

VIII Богд Жавзандамба хутагт нь урьд урьдын дүрүүдээс илүү ялгарч, онц үлэмж их эрч хүчтэй, эрх мэдэлтэй, өндөр нэр хүнд, алдар суутай байсан гэдгийг дотоод, гадаадын олон хүмүүсийн бичиж үлдээсэн, ярьсан дурсамж, архивын эх сурвалжид тодорхой тэмдэглэгдэн үлдсэн байна. XX зууны эхэн үеийн Монголын бурханы шашны тархалт болон хөгжил бол Богдын ёс, тогтолцооны ид оргил байсан бөгөөд тиймээс ч бурханы шашин тархай бутархай монголчуудыг нэгтгэсэн том улс төрийн хүчин зүйл болж, түүний улмаас бурханы шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт монголчуудын үндэсний тэмцлийг удирдан манлайлж, Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөгдсөн билээ. Богд Жавзандамба хутагт бол монголчуудад дахин сэргэлт өгсөн 1911 оны үндэсний хувьсгалын удирдагч эцэг бөгөөд Монголын сүүлчийн эзэн хаан байв.

* * * * *

Богдын өндөр нэр хүнд, суу алдар

Юуны өмнө VIII Богд Жавзандамба хутагт нь урьд урьдын дүрүүдээс илүү ялгарч, онц үлэмж их эрч хүчтэй, эрх мэдэлтэй, өндөр нэр хүнд, алдар суутай байсан гэдгийг дотоод, гадаадын олон хүмүүсийн бичиж үлдээсэн, ярьсан дурсамж зэрэг зүйлст тодорхой тэмдэглэгдэн үлдсэн байна.

Чухам яагаад ийнхүү өмнөх дүрүүдээс илүү өндөрт хүрсэн бэ гэдэг талаар цөөн зүйл хэлье.

Мэдээж Богд Жавзандамба хутагт нь нийт монгол овогтоны дунд өмнөх дүрүүдийн адил тахин шүтэгдсэн Амьд бурхан хэмээн бишрэн шүтэгдэж байв.

VIII Богд Жавзандамба хутагт таван настайдаа Монголд заларч, ухаан сэргэлэн, төрөлхийн авьяас билгээрээ өөрийн монгол, түвд багш нар хийгээд шавь нарынхаа дунд эгэлгүй нэгэн болж тодорсон байна. Тэрбээр багш нарынхаа заасаныг гойд сурч, эрдэм номонд гарамгай байсаны сацуу Монголын газар нутгийн хаана, хэзээ ган гачиг, зуд турхан, өвчин эмгэг тохиохыг урьдаас мэдэж, өргөн олноо урьдчилан сануулан мэдэгдэж байсан нь нэг бус удаа нотлогдож, улмаар түүнийг илүү улам бишрэх болж, түүний нэр хүнд тэр чинээгээр хүрээгээ тэлэн алдаршиж байжээ. Тэрбээр өөрөө 18 настай ахуйдаа хүндээр өвдөж, гурав хонгийн дараа түүний өвчин ор мөргүй эдгэж илааршсан зэргийг монголчууд жирийн хэрэг бус хэмээн итгэж хүлээж авав.

“Түшээт хан аймгийн бэйс Пунцагцэрэнгийн эцэг гүнгийн зэрэг тайж Цэрэндоржийг Жавзандамба хутагтын сүмийг бэлтгэх модыг манай хошууны нутгаас зөөх ялдарт Хүрээнд бүхий Жалханз хутагтын зэрэг газарт гэр байшин үйлтгүүлэх мод авч олон тэндэх ардыг илүү чирэгдүүлсэн”¹ тул “энэ хэргийн гүн Цэрэндоржийг хоёр есөн мал торгож шийтгэн цээрлэл үзүүлэх” - ээр болтол уг шийтгэл хөнгөдсөн хэмээн үзэж, бусдад үлгэр болгох үүднээс Богд Жавзандамба хутагтын “зарлигийг дагаж даруй харьяат гүнгийн зэрэг гутгаар зэрэг тайж Цэрэндоржийг түшмэлээс эвдэж харьяат хошуунд тушааж чангалан хураалган захируулах”²-аар болжээ.

Богд гэгээний хорин хоёр настай ахуйд буюу 1890 оны орчим Сэцэн хан аймгийн жун ван Доржпалам түүнтэй заалдаж, тэр тухайд Хүрээнд сууж байсан манж амбан сайд Манжийн хаанд хүртэл айлтгасан гэдэг.

Хэрэг явдал хэрхэн өрнөсөн талаар Дээрхийн тухай сударт бичснийг үзвээс,

Арван зургадугаар (1891) он долоон сарын арванд “Очирдара Богд гэгээнтэнээс яаравчлан албаны хүн зарж жүн ван Доржпаламыг арван хоёр хоногийн дотор саадгүй хурданаа ирүүлж надад учруулагтун” хэмээн тушааж айлтгажээ. Гэтэл тушаалыг хүргэсэн хаалгач Ишдоржид жүн ван Доржпалам “энэ хир миний эхийн бие өвчтэй ба, мөн ч тамга хэргийг хараахан дураар өгч явахыг даруй тулгуур олж мэдэхгүй бөгөөд, миний бие энэ удаа бараалхан очиж чадахгүй” хэмээжээ.

Үүнийг сонссон Богд гэгээнтэн дахин “чангалан тушааж”: “хутагт би ван Доржпаламын биеийг хэргийн учир зарлан дуудсан бөгөөд, тэр зүй нь даруй дагаж тухайд тамга хэргийг зохигчдод түр хамааруулан шийтгүүлж нэгэнтэйгүүр харьяат чуулганы дарга нарт мэдүүлээд түүний бие яаравчлан ирж надад учирваас зохих буй за” гээд “дахин элч бичиг довтолгон явуулж уламжлан харьяат жүн ван Доржпаламд чангалан ухуулан шаардан тушаалгаж түүний биеийг эрхбиш маш түргэнээ саадгүй ирүүлж надад учруулагтун” хэмээсэн байна.

Богд гэгээнтний зарлиг ёсоор донир лам Даваа өртөөгөөр довтолгон очиж “ван Доржпаламд харьяат багш Очирдара богд гэгээн таны урьд хожид тушаасан Лүндэнг чангалан ухуулан тушаалгаж түүний биеийг өчүүхэн цаг мөчийн төдийд ч саатуулах зэрэгт хүргүүлэхгүй болгон эрхбиш гавшгайлан мордуулж хурданаа ирүүлж Богд гэгээний лүндэн тааллыг гачигдуулахгүй болгосугай” хэмээжээ.

Жүн ван Доржпалам нараас “манай хошуунд тушааж ялтаныг сахиулах байшинд батлан хадгалуулсан шавь Мөрлэгцэг”-ийн тухай асуудлаар харьцсан бичгүүдийг үзэх аваас, “Жавзандамба хутагтын дэргэд бараа болон явж хэрэг алдсан тус шавь Мөрлэгцэгийн биеийг Лүндэнээр жүн ван Доржпаламын хошуунд чандлан сахиулсан ба мөн жүн ван Доржпаламын биеийг Лүндэнээр хоёр удаа зарлан дуудсан” боловч тэрбээр Хүрээнд хүрч ирээгүй байна.

Энэ тухай айлтгасанд Богд гэгээнтэн сонсоод “би Эзний зарлигаар Халхын бүх монголчуудад тахиулсан бүгдээрийн багш лам хэмээж Халхын шар шажны дундад газрыг эзлэн суугаад харьяат шавь нарын дотроос ийм нэгэн учрыг ухах ихээхэн шавийг зарлан дуудаж учран чадахгүй болвоос үнэхээрийн дээд үеийн хутагт нарын сайн журмыг алдагдуулж Богд эзний түгээмэл хүнд хишгийг хөнгөтгөн гутаахуйд хүргүүлсэн болох”

¹ Дээрхийн уг эх Зургаадугаар дэвтэр 2019:

² Дээрхийн уг эх Зургаадугаар дэвтэр 2019:

тул “ван Доржпалам намайг энэ мэт хүндлэх ёсыг гээгдүүлэхийг үзвээс мөнөөхөн миний газраас тэдний хошуунд хүргүүлэн хадгалуулсан Мөрлэгцэгийг хэрхэн осол сул сахиулж алдах оргоход хүргүүлэхийг болзвоос үл болохын” тул “Мөрлэгцэгийн биеийг эдүгээгээс яаравчлан шилжүүлж улмаар түшээ гүн Жамсранжавын газар хүргүүлэн чангалан баримтлан хадгалуултугай. Мөрлэгцэг болбоос шажин амьтанд нэн хорлолтой болсон хүн бөгөөд намайг багш лам хэмээн бишрэх нь үнэн болбоос эрх биш миний тушаасан ёсоор чангалан хадгалах учрыг түшээ гүн Жамсранжавт ухуулан захьтугай”¹ хэмээн айлтгажээ.

Манжийн хаанаас Хүрээний манж амбан сайдыг уг хэргийг нарийвчлан байцааж, дахин айлтга хэмээсэн байна. Эл тухай амбан сайд Богдод сонсгоход, Богд гэгээн: “Би шашин төрд харштай, олон амьтанд хортой буруу явдал хийсэнгүй атал нэгээхэн хүний үгээр хилс шаардагдахад хүрсэн нь миний үхээнц доройгийн харгайгаар урьд үеийн хутагт нарын сайн алдарыг гутаахад хүрчээ. Тиймийн тул гуйх нь, урьдаар намайг Жавзандамба хутагтын нэрээс байлгаж, жич ял тулган байцааваас монгол орны бурханы шажин хөнгөрөхгүй болмой. Эл хэргийн чухам үнэнийг олоход бэрхгүй. Миний ямарваа явдлыг Халх Монгол даяар мэдэх тул чуулган дарга нар ба олон засгуудаас асууваас тэд нар аяндаа тодорхойлмой. Энэ хэргийн чухам үнэнийг эс олбоос миний гомдол барагдахгүй”² хэмээн хатуугаар айлтгасан байна. Үүнийг мэдээд Манж хаан Богд гэгээний гомдлыг тайтгаруулж, “санаа амар суу. Би хутагтыг хүндэд итгэмүй”³ хэмээн зарлиг бууж, есөн луутай шүхэр шагнасан ажээ. Улмаар заалдагч Доржпаламын жун вангийн хэргэмийн эвдсэн байна. Хожим Доржпалам Богдод буруугаа хүлээн, уучлал эрсэнд, Богд гэгээнээс түүний жун вангийн хэргэмийг дахин олгуулахыг Манжийн хаанаа айлтгаж олгуулсан гэдэг.

Энэ явдлаас хойш монгол ноёд, ихэс дээдэс Богд гэгээнээс ихэд айн сүрдэх болж, түүний зарлиг шийдвэрийг ёсчлон дагах болсон байна.

Чухамдаа XX зууны эхэн үеэр Монголоор аялсан гадаадын аялагчид, сэтгүүлчид Богд нэр хүнд, суу алдар нь ар, өвөр монгол, барга, буриад, халимаг гээд нийт монгол овогтоны төдийгүй Персийн булангаас Япон тэнгис хүртэлх орон зайд түүний суу алдар түгсэн алдартан хэмээн тэмдэглэсэн нь буй. Польшийн аялагч, сэтгүүлч Ф.Осендовский Богд хааны тухай өгүүлэхдээ: “Богд Жавзандамба мариалаг бөгөөд тэргүүнийхээ хуйхыг цайтал үсээ хусуулсан нь Ромын хамба шиг харагдсан. Хар хилэн хиазтай, шар торгон дээл өмсчээ. Амьд бурханы төрх аливаа ламын ёсны дагуу хоёрдмол шинжтэй аж. Тэр нь их ухаантай, номд нэвтэрхий. Сэргэлэн... Өргөөндөө их даруу сууна. Түүний бичгийн хэрэгсэл хятад хийцтэй намхан ширээн дээр байсан”⁴ хэмээжээ.

Оросын Эзэн хааны Газар зүйн нийгэмлэгийн жинхэнэ гишүүн, Ерөнхий штабын гишүүн, хурандаа В.Ф.Новицкий болон цэргийн газар зүйн корпусын гишүүн, гадаах зөвлөх М.О.Круковский нарын тэргүүлсэн экспедиц 1906 онд Ар Монгол, Шилийн голын чуулган, Дотоод Монголын нутгаар аяласан бөгөөд эл аялалын үеэр тэд Хүрээнд ирж, Богдын даншиг наадам үзсэн талаар бичсэн буй. Хурандаа Новицкийн бичснээр 1906 оны 7 дугаар сарын 29-нд Хүй-д Долоон хошуу наадам болжээ. Уг хошууны наадмыг Хүрээн дэх манж амбан, орос консул болон Богд гэгээн нар үзсэн бөгөөд тэд тус тусдаа өөрийн

¹ Дээрхийн уг эх Зургаадугаар дэвтэр 2019:

² Дилов хутагт Жамсранжав Ар Монголын улс төрийн дурдатгал 1991: 6

³ Дилов хутагт Жамсранжав Ар Монголын улс төрийн дурдатгал 1991: 6

⁴ Ф.Осендовский 2006

өргөөтэй байсан байна. Хүй-д ноёд, түшмэд, ард наадамчин олон бүгд цугларсаны дараа Богд Жавзандамба хутагтын морилж байсан ордоноос эхлэх дохио өгөнгүүд наадам эхэлжээ. Наадамын үеэр Хүрээний хутагт Богд гэгээн дагалдагсдын хамт маш том цуваа (баярын гоёмсог шар сүйх тэргэнүүдэд суусан) наадамчдыг тойрч, Хутагт өвдөг сөхрөн мөргөх ард олноо адислаж байв”¹ хэмээн бичжээ. Богд Жавзандамба хутагтын нэр хүнд ард олныхоо дунд хэр зэрэг өндөр болохыг өөрийн нүдээр харснаа В.Новицкий ийнхүү бичсэн буй. Эл сурвалжид наадам хийж буй газрын нэрийг Хүй хэмээн бичснээс үзвэл үүнээс хожим “Хүй долоон худаг” хэмээн нэрлэсэн бололтой. Барон Унгерны цэргийн офицер М.Торновский: түүний бүр багад нь чөлөөтэй, ухаантай хүний шинж харагдаж байжээ. Тэрбээр лам нарын тоглоом болоогүйгээр барахгүй тэднийг бүрэн өөрийн мэдэлд барьж чадсан юм.

Тэрбээр бүр залуугаасаа Чингис хааны агуу их улсыг сэргээдэггүй юмаа гэхэд ядаж Монголыг хятадуудаас чөлөөлж, бие даасан болгохыг мөрөөдөж байв. Ноёд, лам нар түүнээс айж, ард олон түүнийг хайрлаж, түүний алдар хүнд монголын зах хязгаараас хол хальсан байв хэмээн бичжээ.²

Богд Жавзандамба хутагт шашны болон бусад дорнодахины түүх, гүн ухаанд холбогдох ном зохиолуудыг даяанд сууж байгаа юм шиг уншиж, цээжлэн бясалгадаг байжээ.³ Зөвхөн гавжийн дамжаа барихын тулд тус бүр долоон зуугаад хуудас бүхий таван ботийн дайтай ном цээжилж байжээ. Монгол, түвд номын мэргэдтэй ном хаялцаж, 1908 оны зуны дунд сард Их Хүрээний Гандан дахь Гунгаадаржаалин дацанд гавжийн дамжаа барьсан байна. Энэ талаар Дээрхийн тухай сударт тэмдэглэхдээ: “Одоогийн дүрийн Очир дара Богд дахин дахин өлзийгөө өргөж, шашин амьтны тусад түгээмэл буянаа сацруулсан. Энэ нь үнэхээрийн гайхамшигтай онц сайхан хэрэг”⁴ болжээ хэмээсэн буй. VIII Богд бол гавжийн дамжаа барьсан Богд байсан юм. Монголын тухайн үеийн байдал, ирээдүйн талаар Богдын зүүдэлсэн, ярьсан, лүндэн буулгасан үлгэр домог шиг олон зүйлс байдаг билээ. Үүний зах зухаас дуулгах төдийд ийм буюу.

Богд Жавзандамба хутагт монголчуудын шашны тэргүүний хувьд шавь нар хийгээд сүсэгтэн олныхоо буяныг нэмэгдүүлж, хамаг амьтаны тусын тулд эрүүл энх, эе эвийг эрхэмлэсэн зарлиг, лүндэн, сургаал олонтаа буулгасан байдаг. Түүнээс гадна 1911 оноос хойш Монгол Улсын эзэн хааны суудал суугаад буулгасан зарлиг лүндэн нь төрийн тэргүүний хувьд Монгол овогтоны тусын тулд гал голомтоо хэрхэн авч үлдэж, үндэсний тусгаар тогтнол, бие даасан байдлаа хамгаалах, үндэсний уламжлал, зан заншил, ёс суртахуунаа цэвэр ариунаар хөгжүүлэхийн төлөө айлдсан сургаалууд юм. Бидэнд мэдэгдэж байгаагаар Монгол Улсын үндэсний төв номын сан, архив болон Оросын Холбооны Улсын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахины гар бичмэлийн сан,

¹ Путешествие по Монголии в пределах Тушету-хановского и Сэцэн хановского аймаков Халхи, Шилин-гольского чигулгана и земель Внутренней Монголии, совершенное в 1906 году действительными членами Императорского Русского Географического Общества, генерального штаба полковником В.Ф.Новицким и корпуса военных топографов надворным советником М.О.Круковским, Составил В.Ф.Новицкий, С.П., Военная типография 1911: 65

² М.Г.Торновский События в Монголии-Халхе в 1920-1921 годах- Легендарный Барон: неизвестные страницы гражданской войны 2004: 182

³ Г.Жамсранжав Богд хаан 1998: 56

⁴ Үндэсний төв номын сан Дээрхийн тухай гар бичмэл, Долоодугаар дэвтэр

Германы Үндэсний номын сан, Данийн эзэн хааны номын сан¹, Шведийн Стокгольмийн их сургуулийн номын сан, Украины номын сан² зэрэг гадаад орнуудын номын сан, архивуудад Богд гэгээний олон тооны сургаал, лүндэн хадгалагдаж эдүгээ хүрчээ. Тэдний дотор зарим лүндэн, сургаалуудыг эмхтгэж, товхисон, дэвтэрлэсэн байх нь буй ч бас дэвтэрлээгүй задгай хэлбэрээр улаан өнгийн шугамтай, шугамгүй муутуу цаасан дээр үзэг, хулсан бийрээр цэвэр, тогтуун, татлаган хэлбэрээр тухайн үеийн шилдэг бичээч нарын буулгасан зарлиг, лүндэн олон байх юм. Түүнээс гадна Богд гэгээн, Богд хаанд өргөн айлтгасан айлтгал, илтгэлүүд нилээд байх бөгөөд тэдгээр дээр “Зарлиг мэдэв” гэх зэргээр Богдын мутрын тэмдэг дарсан ч бас байна.

Богд гэгээн өөрийн зарлиг, лүндэнгийн эхэнд “хэдэн зүйлийн үг дараалан холбож, та бүхэнд бичиг илгээв” хэмээн бичиж байжээ. Түүний лүндэн, зарлиг агуулга гүн, утга төгөлдөр, алс холыг харсан шинжтэй байдаг нь үеэс үед дамжиж ирсэн Богдын лүндэн, сургаалаас тод харагдана. Тухайлбал, “Энэ оронд би ирээд олон удаагийн үед хувилгаан дүр үзүүлж, амьтанд тус үйлдэж, шар шашныг дэлгэрүүлэн тэтгэж буй бүлгөө”, “Алт, мөнгийг биеэ бүрхтэл эдэлдэг чинь өөрийнхөө дайсан болохын ёр”, “Баян гэж битгий сагсуур. Ядуу гэж бүү гомд. Аливаа хүн сэтгэлээ засч хичээ. Муу үйлийг халж, сайн замаар явбал цөвүүн цагаас гэтлэж болно”, “Та бүхэн миний үгнээс авахыг нь ав. Орхихыг нь орхи. Гагцхүү сүжиг, эвээ хичээ”³ гэх зэргээр Богд гэгээнтэн олон лүндэн, сургаал буулгасан байдаг.

Богд хаантан сургаал, лүндэн буулгахаас гадна эх болсон байгаль дэлхий, энэрэл, хайрлалын талаар бүтээл туурвисан байдаг. Уг бүтээл нь “Дэлхийн сан хийгээд тахилга тэргүүтэн гүн хийгээд бүрнээ хамт оршвай” хэмээх нэртэй юм. Эл судартаа: “уул овооны эзнийг савдаг, улс булгийнхыг лус, түймэрийнхийг салхи хөлөглөсөн тэнгэр” байх талаар тодорхой тусгажээ.

Богд гэгээнтэний “Рашааны урсгал усан оршвой” ном нь бурханы гүн ухаан, ёс суртахуун, винайн ёсны сургаалыг нарийн задалж, тодорхой тайлбарлан хөгжүүлсэн дорнодахины гүн ухааны бүтээл юм. Эл ном 20 хуудастай, хуудас бүр 13 мөртэй, мөр бүр нь 8-9 үгтэй. Эл бүтээлдээ: “өөрийн сэтгэлийн орон бус тул чанарыг тэгшрүүлэн зохио” хэмээн айлджээ.

Богд гэгээн Монгол Улсын эзэн хааны ширээнд заларсны дараахан “Богд хааны увидас, рашааны урсгал усан оршвой” бүтээл зохиосон нь монголчуудын өмнөх үеийн түүхийг тухайн үетэйгээ харьцуулсан, өөрөөр хэлбэл тусгаар тогтносон, бие даасан байдалтай үед яавал зохиолтойг зааж сургасан судар байв. Эл номын эхэнд Манжид дагаар орсон үеийг товч дурдаад эдүгээ “Жавзандамба лам би шашин амьтныг хайрлан тэтгэхийн эрхээр, манж улс хямарсаны шалтгаанаар Халх Монголын амьтнуудыг хамгаалан удирдахын аргаар шашин төрийг хослон баригч хааны ширээнд сууснаас халх Монголын дөрвөн хан нар хийгээд түшмэд тэргүүтэн хамаг амьтнуудын хамт жаргалан, буян цог заль дэлгэрүүлэх, бурханы шашин батдах хийгээд гаднаас харшлах шалтгаан,

¹ Episcopal epistle by the eighth rJebsundampa Khutukhtu MONG 210, Sermon by a rJe-btsun-dam-pa Khtukhtu MONG 283 - The Royal Library, Copenhagen

² Е.Д.Огнева Памятники тибетской письменности в Украине- Память мира: Историко-документальное наследие буддизма 2011: 211

³ Үндэсний төв номын сан, Богдын лүндэн, сургаал, 4666.96

цэрэг хөлгөсөн тэргүүтний аюул үл ирэхийн тул шашин, төр хоёул эзэн Богд хааны нэрийг барьсан болой” хэмээн тэмдэглэжээ.

Цааш өгүүлэхдээ: “Миний харьяатад багтсан албад бүгдээр сонс. Шашнаа мандуулан, тулгар төрөө байгуулсан тэргүүтэн маань бүгд Жавзандамбын өндөр гэгээний шарилын дэргэд сүслэн залбирсаны ач мөн. Бурхан түүний шашны ач тусыг олж гүйцэшгүй. Санаж сэдэшгүй. Цаг үе өөр болсон шүү. Монгол түмнийхээ түүхийг Богд дээдсийн түүх мэт шүт. Тавдугаар Далай ламын зохиосон шашин төр хоёрын сургаал муталбарыг дахин давтан үзэж, үйлийн үрийг машид сэрэмжлэн, цээрлэж үйлдтүгэй. Үйлийн үрд сүсэг хэрэгтэй шүү. Муу үйлт хилэнцийн нөхрийн хэрэгт бүү ор.

Сударт үндэсний гол сайныг хясааны дотроос гаргасан сувд эрихийг хиргүй ухааны хэлхээгээр зэрэгцүүлэн хэлхэж, төгс хувьт төрөлхтний хүзүүний чимэг болгон унжуулсугай”¹ хэмээсэн буй.

Богд Жавзандамба хутагт бүр 19 дүгээр зууны сүүлчээр Оросын эзэн хаанд өөрийн элч төлөөлөгчөө улс төрийн зорилгоор нууцаар илгээж байсан болон 1910 оны дундуур Сайн ноён Т.Намнансүрэн Богдод захидал бичиж, түүндээ Манжаас Халхад хэрэгжүүлж буй шинэ засгийн бодлого нь аюултай болохыг тэмдэглэсэн билээ. Богд Жавзандамба хутагт энэхүү захидалтай танилцаад мөн оны Долдугаар сард Их Хүрээнээ дөрвөн аймгийн хан, ван, ноёдын зөвөлгөөнийг хуралдуулах зарлиг буулгасан билээ.²

Богд Жавзандамба хутагтын шавь, отог сангийн тухайд

ХҮИ зуунаас Монголд хүчтэй дэлгэрсэн бурханы шашин, түүний тэргүүний үйл ажиллагааг илүү ойлгохын тулд Богдын сангийн тухай эрх биш товч боловч дурьдах нь зүйтэй юм. Энэ талаар эрдэмтэн Ц.Насанбалжир гуайн дорвитэй судалгаа бүхий өгүүлэл³ бий билээ.

Анхдугаар Богд өндөр гэгээнд ноёд болон ард олноос лам, хар хүмүүсийг шавь болгон өргөснөөр шавь отогын үүсэл тавигджээ. XX зууны эх болоход Богдын их шавь⁴ хэмээн монголчуудын үлэмж нөлөө бүхий захиргааны нэгж болтлоо өссөн байв.

Шавь нарын засаг захиргааны үндсэн нэгж нь отог байв. Засаг хошуудын нутаг дахь шавь нар нь отог, баг, Хүрээн дэхь шавь нар нь 30 аймгийн харьяалалт багтсан бүтэцтэй байжээ. Академич Ш.Нацагдорж бээр отог нь “гал голомт” хэмээх утгыг

¹ Г.Жамсранжав Богд хаан 1998: 111

² З.Лонжид Богд гэгээнтэн Орос улсаас хэдэн удаа тусламж хүссэн бэ, Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг, Түүх- 6 2007: 70

³ Ц.Насанбалжир Жавзандамба хутагтын сан – Түүхийн судлал, Том 8 1970: 143-153

⁴ **Их шавь** Халх Монголын шарын шашны тэргүүн Богд Жавзандамба хутагт нар өөрийн олон шавьтай байсан бөгөөд тэднийг бусад хутагтын шавь нараас ялгахын тулд Богдын шавь буюу Их шавь хэмээн нэрлэсэн буй. Өөр өөрсдийн өргөсөн хошуудад амьдарч байсан их шавийн ардууд нь тусгай нутаг дэвсгэргүй байсан юм. Манж нар 1639 онд анх үүссэн Халхын шашны тэргүүн Богдын шавь нарыг хэвээр нь үлдээж тэднийг Эрдэнэ Шанзавын яаманд харьяалуулсан. Богдын шавь нь дотроо отогт хуваагдана. Халхад шарын шашин хүчтэй дэлгэрч Хутагтын шавь нарын тоо нь 700 хүрвэл Манжийн хаанаас Хувилсан хутагт хэмээн нэрлэж тамга олгож байсан. Тамгатай 11, тамгагүй 5 хутагт байсан. Шавь нар нь тусгайлсан нутаг дэвсгэргүй ч аймагтай тэнцэх нэгж болон томорч тэднийг Эрдэнэшанзавын яам харьяалдаг байв. 1925 онд Их шавийг халж, Дэлгэрхан уулын аймаг хэмээх шинэ аймгийг байгуулж, их шавийн отгуудыг хошуу болгон өөрчлөн зохион байгуулсан ба тамгатай 13 хутагтын шавь нарыг хошууны зохион байгуулалтанд оруулсан байдаг.

илэрхийлж буй хэмээн бичсэн буй.¹ Анхны отог нь Бөх ламын отог² нэртэй байсан тухай эрдэмтэн Д.Цэдэв тэмдэглэсэн буй. 1767 оны үед Дархад, Баруун хүрээний, Эрдэнэцоржийн, Зүүн Хүрээний, Ачит номун ханы гэх зэрэг 17 отог³ байсаныг их отог хэмээн хожим судлаачид нэрлэсэн буй. Дархадын отог шавь Жавзандамба хутагтын шавь, тусгайлан эзэмшсэн нутагтай шавь нар нь ганцхан хар дархад шавь нар юм. Дархадын отог Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу, Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошуу нутгаар нутаглаж байв.

Их Шавийн отог хэмээх нь аймаг хошуудаас Богдод өргөсөн ард иргэдийг хуваан захирсан орон нутгийн засаг захиргааны нэгж байв.⁴ XX зууны эхэн үеийн шавь отогын талаар Магсар хурц бээр өгүүлэхдээ: "...хуучин хууль дор ороогүй Жавзандамба хутагтын шавийн хүн ам үржиж нэгэн аймгийн адил болсон бөгөөд даруй аймаг хошууны хууль ёсоор явуулбаас зохих боловч тусгайлан олгосон нутаг үгүй бас ч өрх цэргийн албан дор хамаарахгүй тул жинхэнэ засаг хошуун дор адилтгаваас болох үгүй дан гагц баримтлан захирах тоо бүртгэлийн тухай захиргаа байгуулахуй дор урьдах Чин улсын цаг Жавзандамба хутагтын буман шавь арван долоон эх отог хэмээн товч данс үйлдэж Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаа мэдүүлэх ба их отгийн дарга нарыг хүрээний сайдууд дор бие үзүүлэн тавьж Журганаа мэдүүлж явсан данс бүхий нь уул шавийн дотор салбарласан отог, багийн нэр олон байсан боловч тэдгээр их отгуудын нэрийн дор хуваан хавсарган захируулдаг болохын тулд урьд ёсоор явуулан хожим харьяа шавь нарын дотор эрх олон тусгаар шавь хамжлага нутаг таслан авсан эх дагина мөн шавийн тамгатай хутагт ба ван гүн лам нар хийгээд хааяа дагаар орогсдоос хавсарсан шилжиж захируулсан тамгатай хутагтын шавь бэйс гүнгүүдийн хамжлага, ардыг цөм отог хэмээн нэрийдсэний хамт гучин их отог болсон ба мөн халх аймгийн тамгатай хутагт нарын шавь нар нэгэн лүгээ адил отог нэрийдэн бүгд дөчин гурван отог дор засаг хошууны зэрэг дэв олгуулахаар хууль дүрэм тогтоосон зүйл буй" хэмээгээд Жавзандамба хутагтын шавь отгуудыг нэрлэжээ. Үүнд, Баруун хүрээний, Эрдэнэ номун ханы, Хэрлэнгийн, Шадарын, Их барга, Гүенгийн, Хараагийн, Мэргэний, Хараагийн, Завилангийн, Тавнангийн, Хийдчиний, Эрхэмийн, Дархадын, Манзуширийн, Дүйнхэр хутагтын, Тунгалаг билэгт хутагтын, Номч билэгт хутагтын, Эрдэнэ хамба хутагтын, Мэргэн бандид хутагтын, Аграмба ноён цоржийн, Эх дагинын, Чин сүжигт Чин ван ламын, Чин зоригт чин ван ламын, Билэгт нэйс улсад туслагч гүн ламын, Нягт билэгт улсад туслагч гүн ламын, Зоригт баатар бэйсийн, Хөвсгөл нуурын урианхайн гүнгийн, Соёд урианхайн гүнгийн, Харчины итгэлт гүнгийн харьяат отог⁵ гэж нэрлэсэн байна.

Богд Жавзандамба хутагтын сангийн тухайд

Богд Жавзандамба хутагтад шавь нар болон сүсэгтэн олноос өргөсөн мандал даншиг, өргөл барьцын үлэмж их зүйлс, алт, мөнгөн эрдэнэсийн ховор нандин бараа, олон тооны мал, хөрөнгө хуримтлагдсан нь Богд гэгээн болон түүнийг тойрсон бүхий л үйл

¹ Ш.Нацагдорж Монголын феодализмын үндсэн замнал 1978: 146

² Д.Цэдэв Их шавь 1964: 30

³ Ц.Сономдагва Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт \1691-1911\ 1961: 107

⁴ Х.Нямбуу Монголын угсаатны зүй удиртгал 1992: 91

⁵ Н. Магсаржав Монгол Улсын шинэ түүх 2014: 25

ажиллагааны зоог шүүс, гэгээнтэний хувцас, орд өргөө, сүм дугана, хурал номын зардлыг бэлтгэдэг аж ахуй үүсэх шаардлага нэг ёсоор буй болжээ. Анх 1650 онд Богд Жавзандамба хутагтад бараа бологч лам нар сангийн үйл ажиллагаа эрхлэх болж, шанзодба¹ байгуулагджээ. 1651 онд Богдын хүрээнд Андун нар, Жас, Сангай, Зоогой, Хүүхэн ноёны, Дархан эмч, Өрлүүдийн гэсэн долоон аймаг байгуулагдав. Жасын аймаг нь Хүрээ, хийдийн хурал, номын зардлыг бэлтгэх ажлыг, Сангай аймаг нь Богдын сангийн аж ахуйг, Зоогой аймаг нь зоог шүүс бэлтгэх хэргийг тус тусдаа эрхлэн, үйл ажиллагааны зааг ялгаа тогтоосон байна. XX зууны эх болоход Богдын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг аймгийн тоо 30 хүрч, хамгийн сүүлд Эх дагинын аймаг байгуулагдсан гэдэг билээ. Эдгээр аймгууд Богд гэгээнтэний бүхий л үйл ажиллагааг тогтвортой, найдвартай хангах үүргийг хүлээж, түүнийгээ чанартай гүйцэтгэхийн төлөө улс орны өнцөг булан бүрээс төрөл бүрийн чадалтай хүмүүсийг урин залж ажиллуулдаг байв.

Богд Жавзандамбад өргөсөн даншиг, мал хөрөнгө жилээс жилд өссөөр, нэг дүрээс нөгөө дүрд шилжихдээ улам өсөн нэмэгдэж байлаа. Богд Жавзандамба хутагт нь халх монголчуудын шашны тэргүүн тул түүний сангийн сүрэг малаас улаа унахыг хориглож, Манжийн үеийн Халх журмаар эл асуудлыг зохицуулах болов.

1911 оны Монголын үндэсний хувьсгалын дараа сэрсэн Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамба хутагтын зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт уг асуудлыг нарийвчлан зааж оруулсан байна.

Богд гэгээнтэний санг гадаад, дотоод сан хэмээн хоёр хувааж байлаа. Гадаад сангийн дэргэд үржүүлэх сан, дотоод сангийн дэргэд шадар сан тус тус байв. Гадаад сан нь аж ахуй бөгөөд түүнийг “Их сан” хэмээн нэрлэж байжээ. Гадаад сан нь Жавзандамба хутагтын бүх зоог тахил, дугана сүм, орд өргөө, орон сууц барих, засах, хүрээ хийдийн хурал номын зардал нийлүүлэх, мал сүрэг адуулах, үржүүлэх, арилжаа худалдаа хийх, хөсөг тээвэр хөдөлгөх, тариалан тарих, хадлан хадах, мөнгө цай хүү үржүүлэх зээлдүүлэх ба зээлдэн авах, зээлийг төлөх, алба татвар хураах, сангийн орлого зарлагын данс тайлан тооцоо хийх, хөрөнгө хогшлыг бүртгэх, сан шавийн дотор зарцуулах тийз буюу мөнгөн тэмдэгт гаргах, тариалан хадлангийн газар түрээслэх, өргөл барьж хүлээн авах, бадар хандив эрэх, санд ажиллуулах хүмүүсийг сонгон авах зэрэгтэй холбогдсон бүхий л аж ахуй санхүүгийн ажлыг шууд эрхлэн хариуцаж байжээ.

¹ Шанзудба – монголоор мутрын сан баригч хэмээх утгатай үг. Монголын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагтын шавийн хэрэг, засаг захиргаа, санхүү, жас, аж ахуйгаас эхлээд тэдний явах суухыг хүртэл хамааран захирч байсан албан тушаал. Шанзудба нь Манж Чингийн үед Жибзундамба хутагтын Хүрээний хэргийг шийтгэх, шавь нарыг бүгд захирагч Эрдэнэ шанзудбын тамга хэмээх бичигтэй тамгатай байсан нь Жибзундамба хутагтын харьяат бүх шавь нар, тэдний хооронд гарсан зарга заальхай, хүн амь, хулгай худлын хэргийг шүүн таслах, Хутагтын мал сүрэг, сангийн хэргийг эрхлэх, Хүрээтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх эрх мэдэл бүхий тушаалтан байжээ. Эрдэнэ шанзудба нь Манж Чингийн үед Хамба номун ханы хамт Түвэдээс тодорсон Жибзундамба хутагтын дүүргийг Монголд залж авчрах, хутагтын ширээнд өргөмжлөх ажлын Чингийн төрийн хяналт дор халхын дөрвөн аймгийн чуулган дарга нарын хамт зохион байгуулж байжээ. Шанзудба нь Хүрээний хамба номун ханы хамт Хүрээний сүм хийдүүдийн тэргүүлэх тушаалтнуудыг томилох, тэдний хэрэглэх ямба ёсыг тогтоох эрхтэй байжээ. Шанзудба нь гэлэн сахил авдаггүй ба дээр зэргийн улаан шүрэн жинстэй малгай өмсдөг байжээ. Энэ нь түүний эрхэлсэн ажил, тухайлбал шавь нарт холбогдох хулгай худал, хүн амины зэрэг хэргийг шүүн шийдвэрлэх зэрэгт оролцдогтой холбоотой байжээ. 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан Монгол улсын эзэн хаан Богд Жавзандамбын зарлигаар Эрдэнэ шанзудбын яамны суурин дээр Шашин төрд туслах сайдын яамыг байгуулж, уг сайдын албан тушаалд Эрдэнэ шанзудба Бадамдоржийг томилсон билээ. Ингэснээр эрдэнэ шанзудбын эрхлэх асуудлын хүрээ улам өргөжсөн юм.

Дотоод сан нь Богд Жавзандамба хутагтын ордон доторхи бурхан тахилын элдэв хэрэгсэл, алт, мөнгө, шүүр, сувд эрдэнэс, ховор нандин зүйлс, үнэ бүхий хосгүй бараа зэргийг хадгалж хамгаалах, мандал даншгийн харамж, өргөл барьц, бэлэг сэлтийг хүлээн авах, орд сүмд хэрэглэх зүйлийг бэлтгэх ажлыг хариуцаж байжээ. Дотоод сангийн нэгэн хэсэг болох шадар сан нь зөвхөн Богдын ордон дотор өдөр тутмын хэрэглэх элдэв хэрэгсэл хувцас, хунар, ямба ёслолын зэрэг зүйлийг хадгалж байв.

Жавзандамба хутагтын гадаад, дотоод сан хоёул Их шавь нарыг захирах Эрдэнэ шанзодбын яаманд захирагдаж байлаа. Гадаад, дотоод, шадар, үржүүлэх санд нярав, бичээч, тогооч, түлхүүрч, халбагач, хөрөөч, мөнгө төмрийн дархан, мужаан, гар урлалын ажилчин, үйлчин, манаач, цэвэрлэгч, агт морь адуулах жолооч, ногточ, амьтан тэжээгч, саальчин гэх зэрэг ажил хийдэг хэдэн зуун хүмүүс ажиллаж байв. Эдгээр хүмүүс нь шавиас тусдаа гэдгийг хэлэх нь зүй. Жавзандамба хутагтын сүрэг малын тоо 1773 онд 91253 толгой, 1864 онд 118506 толгой хүрч өсөж байсан¹ хэмээн тэмдэглэгджээ. Жавзандамба хутагтын сан мал аж ахуйн зэрэгцээ тариалан, хадлангийн ажил эрхэлж байв. 1775 оноос Жавзандамба хутагтын сан болон түүний харьяа хийдийн жасад тариа тарих газруудыг Түшээт хан аймгийн зарим хошуудын нутгийн Сэлэнгийн сав газар болох Еэвэн, Бургалтай, Бороо, Бор нуур зэрэг газруудад тариа тариулж, цагаан гурил, арвай буудай зэрэг үр тариаг хураан авч байсан мэдээ буй.

1912-1920 онд жил тутам 213 000 гаруй лан мөнгө шавь нараас татвар болгон санд хураан авчээ.²

1911 онд Жавдандамба хутагтыг Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөн залах төрийн их ёслолд олон аймаг, хошуу, шавь, ноёдоос есөн цагааны бэлгэнд морь 3500 шахам, тэмээ 200 гаруй, тэмээний мөнгөн буйл 10 ширхэг, булга, үнэгний арьс 40 гаруй, мөнгө 2100 гаруй лан, бусад үнэт ховор эдлэл, барааг өргөсөн байна.³

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт “Улсын санд хураасан бүх гаалийн 10 хувийн нэг хувь, жич алтны ордоос гарах алтны 10 хувиас 3 хувийг ламын санд шимтгэн олгуулагтун”⁴ хэмээн заасан байна.

1873 онд Эрдэнэ шанзодбын газраас Хүрээний их сангийн тэмдэг хэмээх тийз барлан гаргаж, зөвхөн их сан шавийн дотор хурал номын зардал, алба татвар, өр төлбөрт шар цайны оронд гүйлгэж байжээ. Энэ нь цаасан мөнгөн тэмдэгтийг гаргаж гүйлгээнд хэрэглэж байсан гэсэн үг юм.

Богдын сан ийнхүү олон төрлийн үүсвэрээс их орлоготой байсан боловч Хүрээ хийдийн хурал номын зардал, Богд Жавзандамба хутагт болон түүний шадар хүмүүсийн зардал, Далай лам, Ванчин богдод өргөл барьц барих, Баруун зууд молон хуруулах зэрэгт ихээхэн мөнгө зарцуулж иржээ.

Монгол Улсын тусгаар тогтнол, төр улсаа сэргээн байгуулах үйл хэрэгт Богдын сангаас ихээхэн мөнгө гаргаж байсан гээд улс орны санхүү, аж ахуйтай холбогдолтой томоохон үйл хэрэгт Богдын сангаас мөнгө зарцуулах, эсвэл урьдчилан гаргаад буцаж төлөх зэргээр зарцуулж байсан тухай баримт олон байна. Богд гэгээнтэн 1909 онд Их

¹ Ц.Насанбалжир Жавзандамба хутагтын сан – Түүхийн судлал, Том 8 1970: 145

² Ц.Насанбалжир Жавзандамба хутагтын сан – Түүхийн судлал, Том 8, 1970: 143-153

³ Ц.Насанбалжир Жавзандамба хутагтын сан – Түүхийн судлал, Том 8, 1970: 150

⁴ Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг 2010: 25

Хүрээнд байгуулсан сургуулийн гэрт сангаасаа 10 түмэн лан мөнгө бэлэглэж байсан байдаг.¹

И.М.Майский 1918 оны үеийн Монголын хүрээ хийдийн бүх хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн үнийг 57 сая алтан рублиэр тооцоолон гаргасан байдаг.² 1924 оны Статистикийн мэдээгээр 2 сая 912 520 толгой мал сүм хийдийн мэдэлд байсаны дотор Богд Жавзандамбын шууд мэдэлд 902 000 толгой мал байсан тухай мэдээ буй.³

Монгол манжаас салж, богд монгол улсын эзэн хаан суусан нь

Богд Жавзандамба хутагт монголчуудын дунд шашны талаар үлэмж нэр хүндтэй, монгол хэл, бичиг сайн мэддэг байсан тул үндэсний тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний тэмцэгч түшээ гүн Чагдаржав, Сайн ноён Намнансүрэн, Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан нарын зэрэг хүмүүс түүнийг нягт хүрээлсэн байна. Эрдэмтэн Ш.Сандаг бүр социализмын ид үзэл суртлын оргил үед “Манжийн колончлолын дэглэмийг эсэргүүцсэн монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шууд нөлөөгөөр Монголын феодалууд ч хамрагдаж улс орныг Манжийн эрхшээлээс тусгаарлан тулгар төрөө сэргээн мандуулахад оролцжээ. Феодалуудын энэ хөдөлгөөнийг Жавзандамба хутагт удирджээ”⁴ хэмээн бичжээ.

Ийнхүү цагаагчин гахай жилийн Монголын үндэсний хувьсгал өрнөж, улмаар өвлийн дунд сарын шинийн 9 буюу 1911 оны 12 сарын 29-нд Жавзандамба хутагтыг Монгол улсын эзэн хааны ширээнд өргөмжлөн суулгажээ.⁵ Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаан ширээнд өргөмжлөхөд хэд хэдэн үндэслэл нөлөөлсөн нь дамжиггүй юм. Тухайлбал, тэрээр монголчуудын дунд шашины тэргүүн төдийгүй улс төрийн хамгийн нэр хүндтэй зүтгэлтэн болж амжсан байв. Иймээс бүр 1895 онд Хүрээнд сууж байсан Оросын ерөнхий консул Шишмарев бичихдээ “хэрэв Монголд үндэсний ямар нэгэн хөдөлгөөн гарах аваас түүнийг Богд толгойлоход гайхах хэрэггүй” хэмээн түүний нэр, нөлөөний тухай бичсэн буй.

Богд Жавзандамба хутагт бээр Түвдээс дүрвэн ирсэн Далай ламыг тосч аваагүй тухайгаа тайлбарлахдаа: “Би бол Монголд Түвдээс албан ёсоор залагдаж суугаа лам. Далай лам их боловч тэндээс зугтаж миний албаны газраа амь хоргодож ирсэн хүн. Би донир сойвонгоо явуулж угтуулсан боловч түүнийг хэрэгссэнгүй” гэжээ.

1911 оны үндэсний хувьсгалын үйл хэрэгт Богдын оруулсан үүрэг ролийн тухай асуудлыг хөндөж, эрдэмтэн Т.Төмөрхүлэг бичихдээ: “Богд бээр уул хөдөлгөөнийг биечлэн удирдаагүй юмаа гэхэд Монголыг тусгаар нэгэн улс болгох санааг лав сэдэлцсэн гэдгийг яагаад ч үгүйсгэх учиргүй”⁶ хэмээн тэмдэглэсэн буй.

Нөгөөтэйгүүр Анхдугаар Богд Жавзандамба болох Өндөр гэгээн Занабазар нь Чингисийн алтан ураг болох Түшээт ханы хүү байсан тул түүний хувилгаан дүрүүд нь алтан урагтай шижим холбогдсон хэрэг хэмээн монголчууд үзэж байв. Богд Жавзандамба

¹ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог 2011: 533

² И.М.Майский Монголия накануне революции 1959: 298

³ Д.Батаа Шашин, түүнийг Монголд зохицуулсан нь (1924-1997) 1998: 37

⁴ Ш.Сандаг Монголын улс төрийн гадаад харилцаа, Тэргүүн дэвтэр 1971: 274

⁵ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог 2011: 202

⁶ Т.Төмөрхүлэг Наймдугаар Жавзандамба хутагт ямар хүн байв, Утга зохиол урлаг, 1990 оны дөрөвдүгээр сарын 6-ны дугаар

Монгол Улсын хаанаар өргөмжлөгдсөнөөсөө хойш жил бүрийн цагаан сарын шинийн нэгний өдөр Түшээт хан Гомбодоржийн эцэг Автай сайн хааны өргөөнд Эх дагины хамт очиж, гал асаадаг байсан нь Монголын төрийн уламжлалыг хадгалж буйг харуулсан илэрхийлэл байсан болов уу. Үүнд мэдээж Алтан ургийн ноёд, төрийн томоохон түшмэлүүд нөлөө үзүүлж, Богд хаан ч төрөлхийн ухаан сэргэлэн, мэдрэмтгий хүн тул дэмжсэн хэрэг буй за.

Өвгөн Жамбалын ярианд өгүүлэхдээ: “Өвлийн тэргүүн сарын 15-нд Дашчоймболын дацанд Их сахиус гэж хурал хурдаг юм. Түүн дээр Богд заларч ирэв. Өдөр дундын үед хамба шанзав хоёрыг дуудуулж авчраад: “Би хэдэн муусайн шавь нартайгаа өнөө шөнийн дотор Манж амбаныг барьж Орос консулд өгч тусгаарлана. Та хоёр зөвшөөрөх үү? Гэж асуусанд хамба нь “За” гэсэн” ба Бадамдорж нь: “Хэдий тусгаарлаж болох боловч зарлигийн сайдыг тэгж бариулж болохгүй” гэх зэргээр Богдыг их сурталчилж гэнэ. Ингэхэд Богдоос “чамаас болох, болохгүйг асуусан юм биш, би далан таван махгал бурхандаа даатгаж нэгэнт тусгаарлахаар шийдсэн” гэж хэлээд Шанзавын тамгыг дор нь авч хамбад шилжүүлэн тушааж, Бадамдорж ямар ч эрх мэдэлгүй нэг хэсэг гэртээ суух болов. Тэгээд зул (өвлийн тэргүүн) сарын 15-наас өвлийн дунд сарын шинийн долоон хүртэл хамба, шанзавын тамгыг давхар барьж байв. Мөн өвлийн дунд сарын шинийн 8-ны үед шанзавын тамгыг Бадамдоржид эргүүлэн өгөв”¹ хэмээжээ.

Богдын тухайд Навааннамжил авгай өгүүлэхдээ: “Халх дахины их багш гэгдсэн Жавзандамба лам”² хэмээн дүгнэсэн нь бодит байдалтай нийцэж байсан хэрэг буй за.

Оросын Гадаад яамны мэдээлэлд үндэслэн Санкт-Петербург хотноо суугаа Францын түр хамаарагч де Панафие өөрийн улсын Гадаад хэргийн яамны сайд де Сельвт 1911 оны 12 дугаар сарын 8-нд мэдээ хүргэсэн байна. Тэрхүү мэдээнд өгүүлэхдээ: “Эдүгээ Монголыг энэ үндэстэний дээд шүтээн багш болсон Хутугт удирдаж байна”³ хэмээжээ. Францын Франкфуртер цайтунг сонин 1912 оны нэгдүгээр сарын 10-ны дугаартаа “Монголд болж буй хямрал нь Хятадын (Манж гүрний. –О.Б) сүүлчийн эзэн хаад өөрсдийн улс төрийн үйл ажиллагаагаа удирдлага болгон тус орны шашины тэргүүн Хутагтад дургүйгээ нууж чадаагүйгээс үүдэлтэй юм. Хутагт л Оросуудад хандсан, тэр хүн л Төвдийн Далай лам лугаа адил Хятадын бүрэн эрхт байдалд өшөрхсөн бүлэг хүмүүсийг удирдан чиглүүлсэн”⁴ хэмээн тэмдэглээд Богдын талаар “энэ хоёр дахь амьд Бурхан өөртөө эрэмшиж хуурмаг бодлоор сэтгэлээ зогоож байна. Хутагт нас нэлээд дээр гарсан бөгөөд нанчид сархад болон шашинд үл нийцэх ертөнцийн бусад жаргал цэнгэлд дуртай хүн”⁵ хэмээн бичжээ.

Харин АНУ-ын Е. Т. WILLIAMS Богд хааны тухай бичихдээ: “Хутагт бол Далай лам, Эрдэнэ Ванчин ламын дараа гуравт орох зиндааны амьд бурхан”⁶ хэмээгээд Түвд,

¹ Ц.Дамдинсүрэн Бүрэн зохиол, Дэд боть 1998: 236 -237

² Г.Навааннамжил Өвгөн бичээчийн өгүүлэл 1956: 141

³ Франц болон бусад гадаад хэлээрх Монголын түүхийн холбогдолтой баримт бичгийн эмхтгэл, Эмхтгэн орчуулсан Т.Төмөрхүлэг 2006: 158

⁴ Франц болон бусад гадаад хэлээрх Монголын түүхийн холбогдолтой баримт бичгийн эмхтгэл, Эмхтгэн орчуулсан Т.Төмөрхүлэг 2006: 172

⁵ Франц болон бусад гадаад хэлээрх Монголын түүхийн холбогдолтой баримт бичгийн эмхтгэл, Эмхтгэн орчуулсан Т.Төмөрхүлэг 2006: 172

⁶ *The American Journal of International Law*, Vol. 10, No. 4. (Oct., 1916): 798-808.

Монгол, Хятадад нийтдээ 160 хутагт байдаг, Хүрээний хутагт өөрийн дор 25 000 ламтай бөгөөд нийтдээ 150 000 шавьтай гэж тэрбээр тэмдэглэсэн байна.

Богд Жавзандамба хутагт хаан сэргээн мандуулсан Монголын төрийн тусгаар тогтнолдоо нийт монголчуудыг хамруулахыг зорьж байв. Иймээс Богд хааны зарлигаар Дотоод, гадаад олон монголчуудад нэгдэж, нэгэн улс гэрээ төвхнүүлэхийг уриалсан билээ. Өвөр Монголын 49 хошууны 38 нь Монгол улсад дагаар орохоо илэрхийлсэн байдаг.¹ Энэ байдлыг Ф.Москвитин В.Котвичид 1912 оны 3 дугаар сарын 19-нд бичсэн захидалдаа дараах байдлаар тайлбарласан байна. Тэрбээр бичихдээ: “Өвөр Монголын ноёд Халхтай нэгдэхийг эрмэлзэж эхэлж байгааг та бэлхэнээ мэдэх буй за. Энэ нь тэд Хутагтаар дамжин Оросын дэмжлэгийг олох хэмээсэн тооцоогоор тайлбарлагдана. Харин манай засгийн газар зөвхөн Халхад л дэмжлэг үзүүлэхээр шийдсэн билээ. Нөгөө талаас Халхтай нэгдэхийг уриалсан Хутагтын байдал тэдэнд татгалзсан хариу өгөхөд тун хүнд байна. Үүнээс гарахын тулд Монголын асуудлаар сонинд шуугиан дэгдээх хэрэгтэй байна. Орост хүн ам цөөнтэй Халхтай харьцахаас нэгдсэн Монголтой харилцах нь дээр гэдгийг нотолсон. Бас монголчуудын хувьд хуваагдмал байснаас Хятадын протекторатын дор нэгдмэл байсан нь дээр гэх мэтээр”² хэмээн бичжээ. Цэвээн Жамсрангаас В.Котвичид 1912 оны 3 дугаар сарын 19-нд бичихдээ: “Наран гэрэлт бүх монголчуудыг нэгтгэх найдвар өвөрлөсөөр л байна”³ хэмээжээ. Харин Манлай ван Дамдинсүрэн Богд хаанд Олноо өргөгдсөний хоёрдугаар он Хаврын тэргүүн сарын хорин гурванд бичсэн айлтгалдаа “Хөлөнбуйр газар бол анх удаа манж хошуунаас тасарч дагаар ирсэн бөгөөд зүүн ба өмнөд хоёр газраар цэрэг нэвтрэн ирэх зам буй” тул “Орос улсын хаанд эртхэн шиг Хөлөнбуйрыг дагаар ирсэн учраа нэгэн адил харгалзан хамгаалахыг гуйн явуулбал”⁴ хязгаарын этгээд бат болно хэмээсэн санал тавьж байжээ.

Ийнхүү Богд Жавзандамба хутагт алсын хараатай, цэгцтэй, няхуур бодлого баримталсаны үр дүнд монголчуудын үндэсний тэмцэл амжилт олж, монголын тусгаар тогтнол, төр улсээ сэргээсэн ажээ.

Америкаас ирсэн Ларсон Богдын талаар өгүүлэхдээ түүнийг “санаа сайтай” хүн хэмээн үнэлсэн буй. Түүний тухай ийнхүү гадаадын хүмүүс нилээд бичсэн нь буй боловч Монголын ард олны дунд домог болон яригдсан зүйлс байхаас бус чухам монголчуудын дотроос Богдын эгэл амьдралын талаар бичиж үлдээсэн нь баримт ховор билээ. Харин Улсын төв музейд ажиллаж байсан Дэндэв авгай өөрийн дурдатгалдаа бичихдээ: “1911 он болж, автономит Монгол тогтож, VIII Богд Жавзандамба хаан ширээнд суухад, шашин төрд туслах Сайдын яам гэдэг байгуулагдаж, би тэнд жинхэнэ бичээч боллоо. Энэ үеэс эхлэн ийш тийш илгээн явуулах бичиг, захиа, Богд эзэнд айлтгах бичгийн эхийг хүртэл зохион бичиж байв” хэмээгээд “Би хэвлэх машин дээр ажиллах болж, Лайшийн хувилгааны зохиол гэдгийг хэвлэн гаргасан. Энэ номыг хэвлэв гэж Богдоос над 20 мөнгөн төгрөг шагнасан байлаа”⁵ гэсэн нь Богдоос доод албан тушаалтнууддаа хэрхэн хандаж ирснийг илтгэн харуулсан нэг баримт буй за. Үнэн сонины газар он удаан жил ажиллаж байсан, өндөр настан, Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу буюу Өвөрхангай

¹ Өргөдэй Тайван /Tai-Ping/ Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр: 2006

² В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг 1972: 181

³ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг 1972: 192

⁴ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг 1972: 204

⁵ Өвгөн Дэндэвийн дурдатгал 1961: 7

аймгийн Баянгол сумын харьяат Вандагийн Одгийв гуайд Богдын талаар М.Дугаржав 1944 онд ярихдаа: “Богд гэдэг чинь төвд гаралтайгаас биш жинхэнэ монгол үзэлтэй, монголоо гэсэн хүн байсан гээд наймдугаар Богдыг магтаад, Манжийн талыг үзэн яддаг, сүүлдээ хаан болоод 11 онд автономит байгуулаа биз дээ”¹ хэмээжээ.

Хабаровскийн генерал губернаторын онцгой асуудал хариуцсан түшмэл, гүн Альфред Кайзерлинг (1861-1939) өөрийн дурсамжиндаа ² Хүрээнд зочилж, Богд Жавзандамба хутагт лугаа шатар нүүсэн тухай өгүүлээд Хутагтын талаар маш сонирхолтой зүйлс бичсэнийг энд оруулж байна. Тэрбээр бичихдээ: “Хүрээ бол Дорнодахин дахь бурханы шашины Амьд бурхан–Хутагтын өргөө оршин буй газар бөгөөд Түвдэд Лхас ямар үүрэгтэй байдаг, түүнтэй адил үүргийг Хүрээ Монголд хүлээж байв. Хутагтад Далай ламд үзүүлж байсан лугаа адил бурханлаг хүндлэлийг үзүүлж байв. Нас бие гүйцэнгүүт тэрбээр Бээжингийн ордонд очиж, Эзэн хаанд хүндлэл үзүүлж, тэндэхийн буддын сүмд адислагдах учиртай байв. Учир нь Бээжингийн засгийн газар нас бие гүйцсэн, бие даасан хутагтын нөлөөнөөс айж байсан тул гол төлөв Бээжингээс Хүрээ рүү буцах замдаа адис авсан хутагтууд гэнэт нас барж, түүний орыг хувилгаан дүрд нь шилжүүлдэг байв.”³ Гэтэл энэ хутагт нь нас бие гүйцмэгц Бээжин явах ёстой байтал Бээжингийн болон эргэн тойрныхоо шахалтанд үл автан элдэв шалтаг тоочин аялалыг хойшлуулсаар байжээ. Хүрээнд тэрбээр аюул багатай байсанаас гадна энд Бээжин түүнийг шууд хорлохоос болгоомжилж байв. Тэрбээр Орос тaaламжтай хандаж байсаны зэрэгцээ хэрэв Бээжинтэй харьцаа муудах аваас Орос улс түүнд тусална гэсэн найдлага тээж байв” гээд “Орос, Монголын эл найрамдлыг бэхжүүлэх үүднээс барон Корф намайг Хүрээ рүү томилсон юм” хэмээн тэмдэглэжээ. Түүнийг Хүрээ рүү явахад нь Буриадын Бандид хамба лам хэдэн лам авч явахыг санал болгосон байна. Тэд Ламын өртөө буюу наран шуудангаар Хүрээнд ирсэн байна.

Тэрбээр Хутагт лугаа уулзсан тухай тэмдэглэхдээ: “биднийг шатаар өгсөхөд хоёр талаар нь лам нар эгнэн зогссон байв. Дээд талд биднийг 18 орчим насны бадриун залуу түвд маягаар гоё хувцасласан хутагт хүлээж байв. Тэрбээр бидэнтэй итгэл төгс мэндчилээд суухыг урив. Би түүнд сүлд болон эзэн хааны нэрийн эвхмэл үсгээр чимэглэсэн Барон Корфийн хувийн мэндчилгээг гардуулав. Хутагт ариун олбогноос бүтсэн сэнтийдээ заларч, намайг эсрэг талдаа буй буйданд суулгав. Биднийг алтан царан дээр тавьсан хятад цайгаар дайлав. Бидний хооронд халуун яриа өрнөв. Энэ үеэр би хутагтад зориулан авчирсан бэлгээ задалж, түүнд гардуулахыг хүсэв. Хутагтад телефон утас онцгой таалагдсанаас гадна бас хөгжимт хайрцаг илүү таалагдав. Утасыг шууд ажиллуулж үзсэнээс гадна хөгжимт хайрцагийг асаахад хутагт ихээр хөгжив. Хутагт нэгэн

¹ Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу буюу Өвөрхангай аймгийн Баянгол сумын харьяат Вандагийн Одгийв гуай Профессор С.Ичинноров гуайтай 2009 оны 8 дугаар сарын 20-ны өдөр уулзсан тэмдэглэлээс

² Альфред Кайзерлинг Воспоминания о русской службе, «Академкнига» 2001: 195-207

³ II Богд Жавзандамба хутагт Лувсандамбийдонмитой 1724-1758 онд амьдарч байжээ. Эрдэмтэн мэргэдийн бичсэнээс үзвэл II Богд 1750-над онд гарсан Манжийг эсэргүүцэх хөдөлгөөнийг дэмжсэн байна. Чухамдаа үүний ч улмаас түүнд хор өгөөд тэнгэр рүү илгээсэн ажээ. Улмаар II Богдод хор өгсөн нь илэрч, монголын ард түмэн бослого гаргаж байсан тухай ч тэмдэглэгдсэн байх юм. Чухамдаа II Богдын Манжийг эсэргүүцсэн монголчуудын үндэсний хөдөлгөөнийг дэмжсэн үйлдэл Манж нарт ихээхэн “сургамж” өгчээ. Өөрөөр хэлбэл нас бие гүйцсэн Богдууд манжуудын хувьд “аюултай бие” болж хувирч болох магадлал өндөртэй байжээ. 1759 оноос 1869 оны хооронд 110 жилийн хугацаанд нийтдээ 5 Монголын Богд Жавзандамба хутагт амьдарсан гээд үзвэл тэдний дундаж нас нь 22 болж байна.

богино аяыг сонсоод “морь цогиж байгаа юм шиг” хэмээн дуу алдан инээж байв. Тэрбээр өөрийн шавьдаа эл дууг монгол хэл рүү хөрвүүлэхийг тушааж, тэр дор нь дууны агуулгыг эх хэлээрээ сонсоод сэтгэл хангалуун байв” гэжээ.

Гүн Альфред Кайзерлинг маргааш нь Хутагтын хүлээн авалтад орж, түүнтэй ажил хэрэг ярилцан шатар нүүсэн тухай өгүүлэхдээ: “Би Барон Корфын даалгавраар худалдааны замаар Монгол, Орос хоорондоо ойртох хэрэгтэй талаар ярихад тэнд байсан бүгд дэмжиж байв гээд Хутагт түүнийг шатар тоглодог эсэхийг асууж, улмаар тоглохыг санал болгон тогложээ. Энэ үеэр Хутагтад мөргөлчид нэгэн нэгийнхээ араас мөлхөн ирж адис авч, Хутагт гартаа барьж байсан шатрын бодоор хүртэл адислаж байв. Энэ үед тэрбээр өчигдрийн сонссон хөгжмийн аяаа аялаж байсан нь миний гайхалыг төрүүлж байв. Ийнхүү Штраусын вальсын аянд ард түмнээ адислангаа миний ноёныг шалаж, мат тавив. Би хутагтай уулзсан уулзалтандаа сэтгэл ханан, хүлээн авалтад талархлаа илэрхийлээд гэрийн зүг явав”¹ хэмээн бичжээ. Эл гүнгийн дурдатгал нь Богд Жавзандамба хутагтыг хэр зэрэг бие даасан, эрх чөлөөтэй, алсын хараатай болохыг харуулахын зэрэгцээ түүнд Оростой ойртох санаа бодол нилээд эртнээс суусаныг илтгэн харуулжээ хэмээн үзэж болохоор байна. Тэрбээр шатар тоглодог байсан нь түүний оюун санааны хөгжилд ч зохих хувь нэмэр үзүүлж байсан буй за. Оросын нэрт дипломатч И.Я.Коростовец: “Би Хутагтыг, өөрөөр хэлбэл Богдыг анх удаа гэрийн нөхцөлд ийм ойроос харлаа. Тэрээр ширүүн төрхтэй, өөрийн гэсэн тодорхой үзэл бодолтой хүн шиг надад санагдав”² хэмээн 1913 онд өдрийн тэмдэглэлдээ бичсэн буй.

Бие даасан, ухаантай шашны тэргүүн – удирдагч Төвдийн хувьд ч хятадуудын хувьд ч хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй үе байв. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол улсын төр, шашныг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст Богд эзэн хаан Жавзандамба хутагтын нэр хүнд 1911 оны дараа өмнөх үеэсээ илүү өссөн хэмээн үзэж болно. Учир нь тэрбээр эзэн Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын гал голомтыг сэргээхэд гол үүрэг гүйцэтгэж, амжилт байгуулсан бөгөөд чингэснээр бүх монгол овогтоны дунд хүлээн зөвшөөрөгдсөн лидер болсон юм. Богд хаанд Оросын эзэн хаан хоёрдугаар Николай өөрийн хөрөг зургаа илгээн баяр хүргэсэн бол Буриадын хамба Итгэлт, Халимагийн бурханы шашны тэргүүн нар дараалан элч зарж баяр хүргэсэн байна.

Өвөр Монголын олон хошуудаас Богдын Засгийн газарт баяр хүргэж, дагаар орохоо илэрхийлсэн бичгүүд удаа дараалан ирсэн байна.

Тиймээс Богд хааны нэр хүнд олон монголчуудын дунд өндөр байсан хэмээн үзэхэд болно. Тэрбээр монголын бичгийн эрдэмтэн мэргэдийг дайчлан Монгол үндэстний амин шалгуур болсон түүх, хууль эрх зүйн баримт бичгүүдийг шинээр зохиолгосон байна. Тухайлбал, 1913-1918 онд Богд хааны зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт Богд Жавзандамба хутагтын ёс, тогтолцоог тусгаар тогтносон, бие даасан улсын хувьд нарийн тодорхой зааж өгсөн байдаг. Энэхүү хууль зүйлийн бичгийн 34, 35, 36 дугаар дэвтрүүд нь Лам нарын хэргийн хууль юм. Манжийн үеийн Хууль зүйлийн бичигт 5 дэвтэр 108 зүйл байсаныг Монгол Хууль зүйлийн бичигт 3 дэвтэр 30 зүйл болгосон байна.³

¹ Альфред Кайзерлинг Воспоминания о русской службе, «Академкнига» 2001: 202

² И.Я.Коростовец Монголд өнгөрүүлсэн есөн сар, Составитель О.Батсайхан 2010: 98

³ Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг 2018: 181-193

Богд эзэн хааны Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн 65 дэвтэр зэрэг хууль зарлигуудаар Монгол Улсын төрийн бүтэц, тогтолцоог тогтоон хэрэгжүүлсэн бөгөөд үүний дотор бурханы шашины асуудал тодорхой байр суурь эзэлсэн байдаг. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн 34 дүгээр дэвтэрээс 36 дугаар дэвтэрт Лам нарын хэргийг хуулчилсан нь Манжийн үед ч байгаагүй хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байсан юм.¹ ХЗБ-ийн 34 дүгээр дэвтэр Жавзандамба ламыг өргөмжлөх, Жавзандамба ламын лүндэнг дагаж шийтгүүлэх, Жавзандамба ламын ордоны хэрэг эрхлэн тушаалын орон тоо, Нийслэл Хүрээ ба Их Шавийн харьяат олон сүмийн лам нарын орон тоог хүртэл нэр заан тогтоосон буй. ХЗБ-ийн 35 дугаар дэвтэрт Олон хутагт лам нарын хувилгааны зааж таних, тэдэнд тамга олгуулах, хэрэглэх зүйлс, тушаал хэргэм зэргийг нарийвчлан заан тогтоожээ. Харин ХЗБ-ийн 36 дугаар дэвтэрт аливаа лам, банди нарыг сургах цаазлахыг тогтоон заасан байна.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн 34 дүгээр дэвтэрт Лам нарын хэргийн хууль Дээд дэвтэрт Жавзандамба ламыг өргөмжлөх нь хэмээх тусгайлан заалт оруулж, түүнд: “аливаа яамлаж төрийн хэрэг шийтгэхээс бус ном хурлын газар ба энгийн өдөр Жавзандамба ламыг хаанаас ахлуулж эрхэмлэн өргөмжлөгтүн”² хэмээн заажээ.

Ийнхүү Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын Хуулиар өргөмжлөх болсон нь юуны өмнө түүнд 1874 онд Халх Монголын бурханы шашны тэргүүний сууринд залрахад Манжийн хаанаас олгосон алтан тамга, алтан өргөмжлөлийг хүчингүй болохыг илтгээд зогсохгүй, Жавзандамба хутагтыг тодруулсан Далай лам лугаа зиндаа зэрэгцэх түвшинд ирснийг илэрхийлнэ. Энэхүү хуулинд тусгасан ёсоор Жавзандамба хутагтыг Монгол Улсын хааны зарлигаар 1915 онд өргөмжилж, алтан тамга, алтан өргөмжлөл олгосон нь тусгаар улсын бүрэн эрхт байдлын илэрхийлэл болсон юм.

Улмаар Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн 34-36 дугаар дэвтэрт Нийслэл Хүрээ ба Их Шавийн харьяат олон сүмийн лам нарын тоо зэргийг албан тушаал бүрээр тогтоосноос гадна хамба номун хан, ёнзон хамба, номын хан, дэд хамба, олон хутагт, бандида цорж хувилгаан лам нарын хэрэглэх дээд, хүрэмний өнгийг хүртэл тодорхойлон, эрхлэх албыг нарийн зааж өгсөн байна. Энэ бол Жавзандамба хутагтын ёс, тогтолцоог улам боловсронгуй болгосон эрх зүйн баримт бичиг юм.

Мөн түүнчлэн төрийн сайд, томоохон лам нарын жагсах, суух дарааллыг хүртэл нарийвчлан заасан нь эл үеийн Жавзандамба хутагтын ёс, тогтолцоо хэр зэрэг нарийн зохицуулалттай, дэг журамтай, дээдлэх эрхэмлэх ёсыг хатуу баримталдаг байсаныг илтгэн харуулна.

Дүгнэлт болгох нь

Манжийн үеийн Монголын нөхцөл байдал, засаг захиргаа, хууль эрх зүйн орчины байдалыг сайтар ухаарч харсаны улмаас 1911 оны үндэсний хувьсгалын бүхий л сценарийг нилээд эртнээс VIII Богд Жавзандамба хутагт бичсэн бөгөөд түүнийгээ ч амжилттай хэрэгжүүлж чадсан хэрэг. Үүний улмаас Богдын зөвшөөрөлгүйгээр хэн ч өөр алхам хийж байгаагүй бөгөөд 1911 он гэхэд Хүрээнд ноёдын цугларах, тарах нь хүртэл

¹ Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг 1995.

² Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг 2018: 182

Богдын адисгүйгээр болдоггүй байсаныг эх сурвалжид нэг бус тэмдэглэсэн буй. Нөгөө талаар буддын шашин хэзээ нэгэн цагт монголчуудын омог бардам занг дарахад ашиглагдаж байсан бол XX зууны эхээр монголчуудыг үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэлд нэгэн үзүүрт сэтгэлээр нэгдэж, шарын шашины тэргүүн Богд гэгээнийг үндэсний удирдагч болгоход шууд нөлөөлөл үзүүлсэнийг онцлон тэмдэглэж байна.

Богд хаанаас олон монгол овогтонд хандан гаргасан нэгэн зарлигтаа: “халх Монгол бүхэн миний биеийг язгуурын багш Жавзандамба лам мөн” хэмээн Дээд Богд мэргэдээр заалган, “аглаг холоос урин авчирч, үнэн сүжиг бишрэлээр сүслэн тахисанд миний бие мөн шарын шашныг улмаар өрнүүлэн дэлгэрүүлэх ба монгол овогтон шавь нар бүхнээ гашуун зовлонгоос ангижруулан сайн мөрөөр удирдахыг Дээд лам гурван эрдэнэдээ цаг үргэлж залбиран даатгаж, дөрвөн цаглашгүйг чадахын чинээгээр бясалган ахуйд тэнгэрийн цаг тохиолдож, цагаагчин гахай жилд Чин улсын дотоод олон мужид бошгыг халах намын самуун ихэд дэгдэж, муж бүрийг гагцаар тогтносон завшаанд халхын ихээхэн ноёд лам нар байдал дүрсийг төсөөлөн ухаж, олон монгол овогтон чухам хэрхэн хүмүүжвээс сайн үйл олохыг эрс тодорхойгоор сурган заахыг гуйн өргөсөн тухайд

“Миний бие олон монгол овогтон бусдын эрх мэдэлд харгислан дарлагдах гашуун зовлонгоос ангижран бүгдээр нийлэлдэж, улс болон шарын шашнаа бататган дэлгэрүүлэх цаг болсон. Язгуураас шашин үндэс нэгэн бөгөөд нэгэн адил бишрэн шүтсээр ирсэн ба гашуун зовлонг эдэлж бүхий нь нэгэн чанар” хэмээгээд энэ тохиосон цаг мөчийг алдаж болохгүйг нийт олон монголчуудад анхааруулан бичихдээ: “хэрэв энэхэн сайн цагийн чөлөөг алдвас гэмшивч тус үл болох явдлыг”¹ тэмдэглэсэн буй.

Богд хаан Монгол Улсын эзэн хааны суудалд заларсан тухайгаа өчихдөө: “миний бие Монгол Улсын хаан эзний суурийг хүлээсэн нь ер тоост ертөнцийн хоосон нэрийг эрмэлзэж, олон амьтныг гашуун зовлонд хүргүүлсүгэй хэмээсэн нь бус. Гагцхүү халхын ихээхэн ноёд лам нар чин үнэн сүсгээр хүчлэн гуйсанд хэрхэвч маргаж үл болох түмэн зүйлийн аргагүйгээс. Багш шавийн хүнд журмыг бодож, олны санаанд нийлүүлэн шашин төрийг хослон барьж сүсэг бишрэл төгөлдөр олон монгол овогтон шавь нар юугаан ашдын зовлонгоос үтэр түргэнээ ангижруулах сайн мөрөөр удирдсугай хэмээсэн нь болой” хэмээн өөрийн зорилгоо өгүүлжээ. Богд хаан цагийг алдаж, “монгол овогтон хуваагдан салах ба их хэргийг бүтээн төгсгөж үл чадахад хүргүүлэхийг огтхон ч түвдэхгүй” хэмээн монгол овогтоны цаашдын хувь заяаны талаар санаа зовнин буйгаа ийнхүү илэрхийлж байжээ. Тэрбээр өөрийн зарлигтаа “үлгэрлэвээс эртнээс инагши аливаа хэргийг үүсгэхэд хялбар, төгсгөхөд бэрх” болохыг сануулаад “ялангуяа тулгар төрийг бүтээн байгуулах нь нэн ч хялбар бус” гээд гэвч “үнэнхүү зориг, холын бодлого буй аваас бүтээж үл болох нэгэн ч үгүй” хэмээн сургажээ. Өөрөөр хэлбэл монголчууд сэтгэл, зориг шулуудан нэгийг зоривоос бүтэх учиртайг ухуулсан нь энэ ажээ.

Богд хаан монгол овогтоноо хандан 1915 онд гаргасан эл зарлигтаа: “одоо хэрэв Монгол язгууртаны нэгэн хэсэг нь үүсгэл болон чадвас нэгэн үндэс, нэгэн шашинт олон монгол овогтон хэзээ ч болов хамтдаж үл болох ёсонгүй”² хэмээсэн нь монгол овогтоны гал голомт аль нэгэн хэсэгтээ тухайлбал халх Монголдоо төвлөрөн тогтож үлдвээс алсдаа монгол олон овогтон нэгдэн нийлж болохыг ухуулсан хэрэг байв. Энэ бол Богд хаанаас

¹ Наран гэрэлт түмэн наст Богд хааны зарлиг- Манай Монгол сэтгүүд, 2001, Дугаар 01-02: 35-37

² Үндэсний төв архив Ф:А3, д.1, х.н.563

монгол овогтоны хувь заяанд ямар их анхаарал тавьж, алс хэтийн бодлоготой хандаж байсаныг илтгэх буй за. Энэхүү Богд хааны зарлигийг Монгол Улсын Дээд Доод хуралд уншиж сонсгосон байдаг. Мөн Монгол Улсын таван яам, Шашин төрд туслах сайд, Зүүн, баруун хязгаарын сайд, хутагт гүн, Хөлөнбуйр, Нийслэл Хүрээний цэргийг захирах сайд, Дөрвөдийн зүүн, баруун хоёр аймгийн дарга, Хөвсгөл, Урианхайн гүн, Дарьгангын бүгдийн тэргүүн, Эрдэнэ шанзавын яам, Жирим, Зост, Зуу Од, Шилийн гол, Улаанцав, Их зуу, Хиагтын хоёр этгээд харуулыг захирах гүн, Улиастай, Хиагтын түшмэдэд буухиагаар хүргүүлсэн байдаг.

Буриад болон өвөр монголчууд халх монголчууд лугаа адил Наймдугаар Богдыг “өнгөрсөн, одоо, ирээдүйг нэвт айлдах бөгөөд амьтаныг ганц үр мэт хайрлах нигүүлсэнгүй их авралын манлай” хэмээн биширцгээж байжээ. Сүсэг бишрэл бол ямар ч харгис хатуу үед ямар ч тушаал, ташуураас илүү хүчтэй байдаг байна. Монгол овогтон ийм л итгэл сэтгэлээр Богд гэгээнтэнд хандаж байлаа.

1911 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласан Монгол улсын эзэн хаан Богд Жавзандамба хутагтын зарлигаар Монгол Улсын Засгийн газар орчин үеийн төрийн онолын дагуу төрийн яамдаас бүрдсэний дотор Шанзодбын яамны үндсэн дээр байгуулагдсан Шашин, төрд туслах яам орсон билээ.

XX зууны эхэн үеийн Монголын бурханы шашны хөгжил бол Богдын ёс, тогтолцооны ид оргил байсан бөгөөд тиймээс ч бурханы шашин тархай бутархай монголчуудыг нэгтгэсэн том улс төрийн хүчин зүйл болсон бөгөөд түүний улмаас бурханы шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагт монголчуудын үндэсний тэмцлийг удирдан манлайлж, Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөгдсөн билээ. Богд Жавзандамба хутагт бол монголчуудад дахин сэргэлт өгсөн 1911 оны үндэсний хувьсгалын удирдагч эцэг бөгөөд Монголын сүүлчийн эзэн хаан байв.¹

Тусгаар улсын төрийн тэргүүний хувьд Богд Жавзандамба хутагт бээр анх 1874 онд Монголд залагдаж ирэхэд нь Манжийн хаанаас өргөн барьсан алтан, тамга, алтан навчит өргөмжлөлийг халж, 1915 оны хаврын сүүл сарын арван нэгэнд зарлиг буулгахдаа: “Их Юань улсын хуучин ёсыг дагаж, аливаа яамлах төрийг хэрэг шийтгэх газар хаан би ахлах боловч Жавзандамба лам чамайг шашины эзэн охь манлай”² хэмээн өргөмжилсэн байна. Богд эзэн хааны эл үед Монголын бурханы шашины түүхэнд зуун дамжин орших “80 тохой өндөр Жанрайсиг бурхан” босч, түмэн гэлэнгийн хайлан Нийслэл Хүрээнд хурж байсан нь тодорхой байна.

Богд эзэн хааны тусгаар тогтносон Монгол Улсын тэргүүний хувиар Жавзандамба хутагтыг шашны тэргүүнээр өргөмжилсөн 1915 оны эл зарлигийг үндэслэн хожим 2012 оны 1 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монголын бурханы шашны лам хуврагуудаас өргөмжилсөн IX Богд Жавзандамба хутагтыг Монголын бурханы шашины тэргүүнээр баталгаажуулсан билээ.³ Ийнхүү 1924 онд Монголын төр, шашныг хослон барьсан VIII Богд Жавзандамба хутагт таалал болсоноос хойш Монгол Улсын газар нутагт бурханы шашины тэргүүн тодрох нөхцөл бүрдсэн төдийгүй монголчуудын түүхийн сүүлийн дөрвөн зуун жилийн түүхэнд бурханы шашны тэргүүнээр монгол хүн

¹ О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог 2011: 604

² О.Батсайхан Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог 2011: 202

³ О.Батсайхан IX Богд Жавзандамба хутагт: амьдрал ба цаг хугацаа 2015.

төрөх боломж тохиож, Богд Жавзандамба хутагын ёс, тогтолцоо жинхэнэ ёсоор хөгжих боломж гарч буй хэмээн бодно.

НОМ ЗҮЙ

1. Альфред Кайзерлинг Воспоминания о русской службе, «Академкнига», Москва, 2001.
2. Батаа Д. Шашин, түүнийг Монголд зохицуулсан нь (1924-1997), Улаанбаатар, 1998.
3. Батсайхан О. Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог, Улаанбаатар, 2011.
4. Батсайхан О. IX Богд Жавзандамба хутагт: амьдрал ба цаг хугацаа, Улаанбаатар, 2015.
5. Дамдинсүрэн Ц. Бүрэн зохиол, Дэд боть, Улаанбаатар, 1998.
6. Дилов хутагт Жамсранжав Ар Монголын улс төрий дурдатгал, Монгол бичгээс кирилл үсэгт буулгасан Б.Буянцог, Улаанбаатар, 1991.
7. Жамсранжав Г. Богд хаан, Улаанбаатар, 1998.
8. Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг, монгол бичгээс кирилл үсэгт буулгаж, эрхлэн хэвлүүлсэн О.Батсайн, З.Лонжид, Ч.Хажидсүрэн, Улаанбаатар, 1995.
9. Коростовец И.Я. Монголд өнгөрүүлсэн есөн сар, Составитель О.Батсайхан, Улаанбаатар, 2010.
10. Котвичийн В. хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Судлан хэвлүүлсэн акад.Б.Ширэндэв, эрхэлсэн акад.Ш.Нацагдорж, Улаанбаатар, 1972.
11. Лонжид З. Богд гэгээнтэн Орос улсаас хэдэн удаа тусламж хүссэн бэ, Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг, Түүх- 6, УБ., 2007.
12. Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх, Улаанбаатар, 2014.
13. Майский И.М.Монголия накануне революции, Москва, 1959.
14. Навааннамжил Г. Өвгөн бичээчийн өгүүлэл, Улаанбаатар, 1956.
15. Наран гэрэлт түмэн наст Богд хааны зарлиг- Манай Монгол сэтгүүл, 2001, Дугаар 01-02.
16. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал, Улаанбаатар, 1978.
17. Нацагдорж Ш. Сум, хамжлага, шавь ард, Улаанбаатар, 1972.
18. Насанбалжир Ц. Жавзандамба хутагтын сан – Түүхийн судлал, 1970, Том 8.
19. Нямбуу Х. Монголын угсаатны зүй удиртгал, Улаанбаатар, 1992.
20. Огнева Е.Д. Памятники тибетской письменности в Украине- Память мира: Историко-документальное наследие буддизма, Материалы международной научно-практической конференции, Москва, 25-26 Ноября, 2010 г., Ответственный К.Орлова, Москва, 2011. Осендовский Ф. Хүмүүс, амьдрал, бурхад, Улаанбаатар., 2006.
21. Өвгөн Дэндэвийн дурдатгал., Улаанбаатар, 1961.
22. Өргөдэй Тайван /Tai-Ping/ Үхэр жилийн үймээний гэрэл ба сүүдэр, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2006.

23. Үндэсний төв архив Ф:АЗ, д.1, х.н.563
24. Үндэсний төв номын сан Дээрхийн тухай гар бичмэл, Долоодугаар дэвтэр
25. Үндэсний төв номын сан, Богдын лүндэн, сургаал, 4666.96
26. Путешествие по Монголии в пределах Тушету-хановского и Сэцэн хановского аймаков Халхи, Шилин-гольского чигулгана и земель Внутренней Монголии, совершенное в 1906 году действительными членами Императорского Русского Географического Общества, генерального штаба полковником В.Ф.Новицким и корпуса военных топографов надворным советником М.О.Круковским, Составил В.Ф.Новицкий, С.П., Военная типография, 1911.
27. Цэдэв Д. Их шавь, Улаанбаатар, 1964.
28. Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу буюу Өвөрхангай аймгийн Баянгол сумын харьяат Вандагийн Одгийв гуай Профессор С.Ичинноров гуайтай 2009 оны 8 дугаар сарын 20-ны өдөр уулзсан тэмдэглэлээс
29. Сандаг Ш. Монголын улс төрийн гадаад харилцаа, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1971.
30. Сономдагва Ц. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт \1691-1911\, Улаанбаатар, 1961.
31. Торновский М.Г. События в Монголии-Халхе в 1920-1921 годах- Легендарный Барон: неизвестные страницы гражданской войны, Составитель и редактор С.Л.Кузьмин, Москва, 2004.
32. Төмөрхүлэг Т. Наймдугаар Жавзандамба хутагт ямар хүн байв, Утга зохиол урлаг, 1990 оны дөрөвдүгээр сарын 6-ны дугаар
33. Франц болон бусад гадаад хэлээрх Монголын түүхийн холбогдолтой баримт бичгийн эмхтгэл, Эмхтгэн орчуулсан Т.Төмөрхүлэг, Улаанбаатар, 2006.
34. The American Journal of International Law, Vol. 10, No. 4. (Oct., 1916), pp. 798-808.
35. Episcopal epistle by the eighth rJebtsundampa Khutukhtu MONG 210, Sermon by a rJe-btsun-dam-pa Khtukhtu MONG 283 - The Royal Library, Copenhagen

ABSTRACT

At the earliest of the XX century, there were a several thousands of families, 100.000 persons, 20.000 monks and over 100 monasteries together with their affiliated jas under the direct rule of the Ikh Shavi [Eng.Higher Disciples] of His Holiness the VIII Bogd Jebtsundamba [Tib.Jetsun Tampa]. In order to know more about His Holiness the 8th Bogd Jebtsundamba, we should know that there were more than 100.000 monks and 1.000 monasteries carrying out their religious activities under the indirect rule of spiritual figure. The disciples of His Holiness were those who were offered to him from various khoshuus [Eng. administrative units]. Although the number of his disciples grew bigger, they did not have any specific land to own. The reason is His Holiness was highly recognized and respected the most by Mongolians. As His Holiness the first Bogd Jebtsundamba (formerly known as Zanabazar or Jnana Vajra) was born in the royal family of Tusheet Khan, he, accompanied by his disciples and subject arats [Eng. commoners], was granted a special permission to move and settle down freely in any land within the province.